

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙН ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоохдоо Шүүх шинжилгээний тухай хуулийн 40.2 дахь хэсэгт заасан нөхцөлийг харгалзан үзнэ.

1.3.Шинжилгээг хийхдээ Шүүх шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад эрх зүйн акт болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр.Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахад тавигдах нийтлэг шаардлага

2.1.Эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн шүүх шинжилгээний байгууллагын сэтгэцийн эмч, сэтгэл зүйч нар гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох шинжилгээг хийнэ.

2.2.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүн нас барсан бол хохирогчоор тогтоогдсон гэр бүлийн гишүүний сэтгэцэд учирсан хор уршгийг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.4, 511.5-д заасны дагуу арилгана.

2.3.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжилгээнд хохирогчийг өөрийн биеэр ирүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хавтаст хэргийн материал болон эмнэлгийн баримт бичиг, материалыг хамт ирүүлнэ.

2.4.Шинжлүүлэгчийг шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад байрлуулан шинжилгээг хийж болно. Эрүүл мэндийн байгууллагууд шинжлүүлэгчийн өвчний түүх, бусад шаардлагатай баримт материалыг шинжилгээ хийх эрх бүхий албан тушаалтанд саадгүй гаргаж өгөх ба төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг хийх үүрэг хүлээнэ.

2.5.Шинжилгээг батлагдсан аргачлалын дагуу хийх бөгөөд энэхүү аргачлал нь нууцлалтай байна.

2.6.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3-д заасны дагуу шинжлүүлэгч нь Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, аймаг, дүүргийн

нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн эмнэлэгт сэтгэцийн үзлэг, шинжилгээгээр сэтгэцэд учирсан хямрал, эмгэг буюу өвчний олон улсын 10 дугаар ангиллын F(4) оношийн бүлэглэлд хамаарч байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

2.7.Шүүх шинжилгээний хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэг бүлэг (Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг), 17.1 дүгээр зүйл (Хулгайлах), 17.3 дугаар зүйл (Залилах),17.12 дугаар зүйл (Мал хулгайлах), 27.10 дугаар зүйл (Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих) гэсэн гэмт хэргийн хохирогчдод дараах “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийн хүснэгт”-ээр сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож болно:

Эрүүгийн хуулийн 11, 17, 27 дугаар бүлгийн гэмт хэргийн зүйл, анги	Шалгуур шинж	Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл
		Маш хүнд
11.1; 11.3; 11.4.2; 11.7; 27.10.2.3; 27.10.2.4;	Харилцааны хувьд утгагүй, хэрэггүй зүйлийн талаар ярих, эсвэл ажил мэргэжил, сургууль ба гэр бүлийн харилцаа, сэтгэл санааны байдлаа шүүж, тунгааж бодох, дүгнэлт хийх чадваргүй болох, сэтгэл санааны гутралд орж найз нөхдөөсөө холдох, гэр бүлээ орхих, ажил эрхлэх чадваргүй болох, насанд хүрээгүй хүүхэд өөрөөсөө бага насны хүүхдүүдийг зодох, хичээл сургуульдаа хоцрогдох, үгэнд орохгүй байх, хий юм харах, сонсох, түүндээ итгэн үйлдэл хийх эсвэл харилцаа нь тогтворгүй, маш бүдүүлэг байх эсвэл амьдралын энгийн үйл ажиллагаанд оролцох чадваргүй байх (өдөржингөө орондоо байх, ажилгүй, гэр оронгүй эсвэл найз нөхөдгүй байх) зэрэг шинжүүд илрэх.	Хүнд
11.2; 11.4.1; 11.5; 27.10.1; 27.10.2.1; 27.10.2.2;	Сэтгэл хөөрөл байхгүй, яриандаа төөрөгдөх, хааяа багтарч уурлах, сандрах эсвэл ажил болон сургууль зэрэг нийгмийн харилцааны асуудалтай болох, найз нөхөд, ажлын хүмүүстэй маргах, зай барих, амиа хорлох сэдэл гаргах, ойр ойрхон хулгай хийх, найз нөхөдгүй, ажил эрхлэх чадваргүй болох зэрэг шинжүүд илрэх.	Хүндэвтэр
11.6.2; 17.1.2; 17.1.3; 17.2.2;	Гэр дотроос хулгай хийх, гэр бүлийн хүмүүстэй маргалдах, гэр бүлийн маргааны дараа төвлөрч	Дунд

17.2.3; 17.3.2; 17.3.3; 17.12.2; 17.12.3;	чадахгүй байх, ажил мэргэжилдээ болон хичээл сургуульдаа хоцрогдолтой байх сэтгэл санаагаар унах, хөнгөн зэргийн нойргүйдэлт үүсэх, гэхдээ ерөнхийдөө амьдралын өдөр тутмын бүх төрлийн үйл ажиллагаанд оролцоно, өөрт нь чухал хүмүүстэй асуудалгүй харилцаа үүсгэх зэрэг түр зуурын шинжүүд илрэх.	
11.6.1; 17.1.1; 17.2.1; 17.3.1; 17.12.1	Амьдралын идэвхтэй, ерөнхийдөө амьдралд сэтгэл хангалуун, өдөр тутмын хэвийн асуудлаас өөр зүйл байхгүй, амьдралын өдөр тутмын бүх төрлийн үйл ажиллагаанд өндөр түвшинд оролцох, шинж тэмдэг байхгүй эсвэл маш бага (Жишээ нь: шалгалтын өмнөх бага зэргийн сэтгэл зовнил) зэргийн шинжүүд илрэх.	Хөнгөн

Тайлбар: Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох хүснэгт нь сэтгэцийн тулгамдсан асуудал болон сэтгэцийн эмгэгийн оношийг тодорхойлоход эрх бүхий байгууллагаас баталсан гарын авлага, өвчний ангилал, сэтгэцийн үйл ажиллагааны чадамж, ангилал, судалгаанд үндэслэсэн хүлээн зөвшөөрөгдөхүйц оношилгоонд тулгуурлан сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг гэмт хэргийн төрөл тус бүрээр ялгамжтай тогтоож, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартад нийцсэн, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалжийн шинжийг агуулсан тул шинжээчийн дүгнэлттэй адилтган үзнэ.

2.7.1.“Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийн хүснэгт” дэх тухайн гэмт хэргийн улмаас учирсан өвдөлт, зовуурь, шаналал болон сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг шинжээчийн дүгнэлтийн хэмжээнд гаргасан хүснэгтээр, хохирогч зөвшөөрөөгүй бол шинжилгээ хийж, эсхүл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шаардлагатай гэж үзэж шинжээч томилсон тохиолдолд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана.

2.7.2.Хүснэгтээр тогтоогдсон зэрэглэл нь тус журмын 4.4-т заасан зарчмыг баримтлан сэтгэцэд учирсан хор уршгийн дээд хэмжээг зааж өгсөн ба хохирогч зөвшөөрөөгүй, эсхүл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шаардлагын дагуу хийсэн шинжилгээний дүгнэлтээр зэрэглэл тогтоогдохгүй эсхүл зэрэглэл буурсан бол шинжилгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэнэ.

2.7.3.“Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийн хүснэгт” нь сэтгэцийн өвчний оношийг тодорхойлоход эрх бүхий байгууллагаас баталсан гарын авлага, өвчний ангилал, сэтгэцийн үйл ажиллагааны чадамж, ангилал, түүнчлэн тодорхой судалгаанд үндэслэсэн хүлээн зөвшөөрөгдөхүйц оношилгоонд тулгуурлан сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг гэмт хэргийн төрөл тус бүрээр ялгамжтай тогтоож, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартад нийцсэн, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалжийн шинжийг агуулсан тул шинжээчийн дүгнэлттэй адилтган үзнэ.

2.7.4. “Тухайлсан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийн хүснэгт”-ийн доод зэрэглэлд илэрч болох шалгуур шинжүүд түүний дээд зэрэглэлийн шалгуур шинжид нэгэн адил хамаарна.

Гурав.Шинжилгээ хийх сэтгэцийн эмч, сэтгэл зүйчид тавигдах шаардлага

3.1.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг сэтгэцийн үндсэн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмч, мэргэжлээр ажилласан сэтгэл зүйч (цаашид “шинжээч” гэх) хийнэ.

3.2.Шинжээч нь зөвшөөрөгдсөн аргачлалыг ашиглаж хувь хүний сэтгэл зүйн оноцлогийг оношлон тодорхойлох, үнэлгээ хийх, үр дүнг зөв тайлбарлах, тохирох арга зүйг сонгон хэрэглэх чадвартай байна.

3.3.Шинжээч нь шинжлүүлэгчийн сэтгэл зүйн байдалд тохируулан харьцаж, оношилгоонд хэрэглэж буй асуумж, үр дүнг боловсруулах арга зүй болон шинжилгээний дүгнэлтийн нууцлалыг хадгалж, хариуцлагатай хандана.

3.4.Мэргэжлийн ёс зүй, байгууллагын дотоод журмыг баримтлан ажиллаж эмгэг сэтгэл судлалын болон сэтгэц оношилгооны чиглэлээр тогтмол сургалтад хамрагдаж, мэдлэг, мэргэжлээ байнга хөгжүүлнэ.

3.5.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрт тусгагдсан асуулт тус бүрд шинжлэх ухааны үндэслэл бүхий хариулт өгөх ба шинжилгээ хийх үед уг хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдал шинээр илэрсэн бол энэ талаар дүгнэлтэд тусгана.

Дөрөв.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийх аргачлал

4.1.Шинжилгээ хийх аргачлал нь хүүхдийн, насанд хүрэгчдийн, сэтгэцийн эмгэгтэй хүний гэсэн хэлбэртэй, анхдагч, дахин шинжилгээний гэсэн төрөлтэй байх бөгөөд бүх хэлбэр, төрлийн аргачлалын асуумж, үр дүнг боловсруулах арга зүй нь нууцлалтай байна.

4.2.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан Эрүүгийн хуулийн 14 бүлгийн 85 гэмт хэргийг гэмт хэргийн хохирол, хор уршиг, ангилал, хүний биед учрах эрүүл мэндийн хохирлын зэргийг үндэслэн 4 бүлэгт хувааж, бүлэг тус бүрээр хор уршгийн зэрэглэл тогтооно.

4.3.Бүлэгт тохирсон асуумж, үр дүнг боловсруулах арга зүй ашиглаж сэтгэцэд учирсан хор уршгийг **хөнгөн, дунд, хүндэвтэр, хүнд, маш хүнд** гэсэн зэрэглэлээр тогтооно.

4.4.Энэ журмын 4.2-т заасан бүлэглэсэн гэмт хэргийн хохирогчдын сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоохдоо дараах хүснэгтийг баримтална:

Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл	Нэгдүгээр бүлгийн гэмт хэргийн хохирогч	Хоёрдугаар бүлгийн гэмт хэргийн хохирогч	Гуравдугаар бүлгийн гэмт хэргийн хохирогч	Дөрөвдүгээр бүлгийн гэмт хэргийн хохирогч
Маш хүнд	Тогтооно	-	-	-
Хүнд	Тогтооно	Тогтооно	-	-
Хүндэвтэр	Тогтооно	Тогтооно	Тогтооно	-
Дунд	-	Тогтооно	Тогтооно	Тогтооно
Хөнгөн	-	-	Тогтооно	Тогтооно

4.5.Шинжилгээ хийх аргачлалын асуумж, үр дүнг боловсруулах арга зүй, хэрэглэгдэх материал нь шинжээчийн хяналтад нууцлалтайгаар хадгалагдах бөгөөд 3 жил тутамд шинэчилнэ.

Тав.Шинжилгээг шинжээчдийн багаар хийлгэх

5.1.Дараах тохиолдолд шинжилгээг багаар хийж болно:

5.1.1.шинжилгээ нарийн төвөгтэй, цар хүрээ ихтэй;

5.1.2.төрөлхийн болон олдмол сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй;

5.1.3.сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох дахин шинжилгээ хийхэд.

5.2.Шинжилгээг багаар хийлгэх шаардлагатай гэж үзвэл шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн 2-оос доошгүй шинжээч хийнэ. Мөн шаардлагатай тохиолдолд шинжилгээнд төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг оролцуулах хүсэлтийг шинжилгээ томилох эрх бүхий этгээдэд гаргана.

5.3.Дахин шинжилгээг багаар хийхдээ шүүх шинжилгээний байгууллагад ажиллаж буй нэг ба түүнээс дээш шинжээчийг багийн бүрэлдэхүүнд оруулах бөгөөд өөр байгууллага, бусад этгээдээр энэ хэлбэрийн шинжилгээг дангаар хийлгэхгүй.

Зургаа.Шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

6.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасан гэмт хэрэг гарсан өдрөөс хойш 7-10 хоногийн дараа шинжилгээ хийнэ.

6.2.Шинжилгээнд шинжлүүлэгчийн нас, тухайн хэргийн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, чанар зэргийг харгалзан сэтгэцийн эмчийн үзлэг, сэтгэл зүйн болон сэтгэц физиологийн үзүүлэлт, багажийн шинжилгээ (полиграф, эгоскоп, тархины цахилгаан бичлэг гэх мэт), эмгэг сэтгэл судлалын шинжилгээ, ажиглалт, бусад арга, хэрэглэгдэхүүнийг ашиглана. Шаардлагатай гэж үзвэл онош тодруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд илгээж болно.

6.3.Шинжлүүлэгчид илэрсэн эмгэг өөрчлөлт, багажийн болон лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн баримт бичиг, бусад материалыг нэгтгэн үнэлж үзсэний үндсэн дээр шинжээч сэтгэцийн өвчний олон улсын ангиллын дагуу шинжилгээний онош тавина.

6.4.Нэмэлт болон дахин шинжилгээг хийхэд өмнө гаргасан дүгнэлтийн

шинжилгээний объект, шинжилсэн явцыг дурдаж, нэмж хийсэн ажиллагааны үр дүнг тусгасан байна.

6.5.Шинжээчийн дүгнэлтэд мэргэжлийн болон орчуулах боломжгүй гадаад нэр томъёог олон улсын нэршлээр хэрэглэж болно.

6.6.Шинжилгээг Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу “шинжилгээ хийх жишиг хугацаа”-нд хийнэ.

Долоо.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээний зардал

7.1.Шинжилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14 дэх хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

7.2.Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасны дагуу шинжилгээний зардлыг гэм буруутай этгээд нөхөн төлнө.

Найм.Хариуцлага

8.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---